

ДОРНОГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/85

Улаан-Уул

Газар эзэмшүүлэх, ашиглуулах
дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэг, "Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг батлах тухай Монгол улсын Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 06/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын "Газар зохион байгуулалтын 2026 төлөвлөгөө"-нд тусгагдсан газарт газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.


3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг 2026 оны 06 дугаар сарын 24-ны өдөр зохих журмын дагуу танхимын хэлбэрээр зохион байгуулахыг Эрдэнэ сумын газрын даамал (Б.Эрдэнэчимэг)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Г.Болдсайхан), Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Алтанцацрал) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА И.БАТСҮРЭН



Сумын Засаг даргын 2026 оны 05
дугаар сарын 18-ний өдрийн А/85
дугаар захирамжийн хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Газрын байршил	Газрын зориулалт	Талбай н хэмжээ (га)	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Дуудлага худалдааны анхны үнэ (төг)	Дэнчингийн хэмжээ (төг)
1	Дөрвөлж баг Долоодын хөндий	Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	20394	5113659	407880	40788
2	Дөрвөлж баг Долоодын хөндий	Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	945	5113661	18900	1890
3	Цагаан хөтөл баг Долоодын хөндий	Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	17694	5113663	353880	35388